

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/100/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Аудитор: Т.Гандолгор
Утас: 325093 Цахим хаяг: gandolgort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠒᠐25, 03, 14 № 01/318

танай _____ -ны № _____ -т

ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭН
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.ЭНХЖАРГАЛАН ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар аудитад шаардлагатай баримт материалыг бүрэн ирүүлээгүй, үйл ажиллагааны журам, бүтэгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөө, байгууллагын стратеги, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зэрэг байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд мөрдөх бодлогын бичиг баримтуудыг боловсруулаагүй, мөнгөн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг хэрэгжүүлээгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан, шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг байршуулаагүй зэрэг 3,500,079.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ болон шинж чанарын хувьд санхүүгийн тайланд материаллаг бөгөөд мөн өргөн тархсан байна.

Энэ нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг",

© Ulaanbaatar, Mongolia 2025 1425010176

"Тохиолдсон байх", "Оршин байх", "Толилуулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай, өмчийн хэлбэр 1 хүний өмч байна.

Байгууллагын нэр дээрх 126,661 м2 газрыг хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК нь 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр 100.0 хувийн хувьцаа эзэмшигчээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлаагүй, компанийн гүйцэтгэх захирал Нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	703,334,948.29	134,422,842.74
1.1.02	Дансны авлага	1,250,762.57	28,354,000.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.04	Бусад авлага	133,000.00	87,900,079.47
1.1.05	Бараа материал	27,272,727.27	81,808,366.94
1.1.06	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	7,673,404.78
1.1.07	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.08	Эргэлтийн хөрөнгийн дүн	731,991,438.13	341,416,070.79
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,405,411,070.15	3,822,831,673.80
1.2.02	Биет бус хөрөнгө	-	-
1.2.03	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,405,411,070.15	3,822,832,673.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,137,402,508.28</u>	<u>4,164,248,744.59</u>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	7,308,476.99	135,553,326.11
2.1.1.02	Татварын өр	81,011,044.01	58,296,057.34
2.1.1.03	Урьдчилж орсон орлого	-	59,000,000.00
2.1.1.04	Богино хугацаат өр төлбөрийн дүн	88,319,521.00	252,849,383.45
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Өр төлбөр	-	-
2.1.2.03	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	88,3319,521.00	252,849,383.45
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	1,870,630,342.00	1,893,050,342.00
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.04	Хуримтлагдсан ашиг	466,657,141,599.89	652,879,451,567.38
2.3.04.1	Тайлангийн үеийн ашиг	1,975,666,723.28	1,815,563,097.14
2.3.04.2	Өмнөх үеийн ашиг	-	-
2.3.05	Эздийн өмчийн дүн	4,049,082,987.28	3,911,399,361.14
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>4,137,402,508.28</u>	<u>4,164,248,744.59</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,761,933,893.58	3,453,818,383.75
2	Борлуулалтын өртөг	167,297,747.25	1,257,953,091.39
3	Нийт ашиг(алдагдал)	1,594,636,146.33	2,195,865,292.36
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	50,495.30
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
8.1	Орлогын дүн	1,594,636,146.33	2,195,865,292.36-
9	Борлуулалт, маркетингийн зардал	380,817,939.46	372,170,437.05
10	Ерөнхий ба удирдлагын зардал	402,188,884.52	1,021,543,181.71
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
12.1	Зардлын дүн	783,006,823.98-	1,393,713,618.76
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	1,878.87
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(999,680,838.12)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)		
17.1	Олз, гарзын дүн		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	811,629,322.35	(197,476,790.35)
19	Орлогын татварын зардал	81,162,932.23	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	730,466,390.12	(197,476,790.35)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	2,073,416,264.00	1,287,181,254.16	3,171,567,496.16
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	2,073,416,264.00	1,287,181,254.16	3,171,567,496.16
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	730,466,390.12	730,466,390.12
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	(41,980,82)	(41,980,921)
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	2023 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	2,073,416,264.00	1,975,666,723.28	3860,052,965.28
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	37,373,164.21	37,373,164.21
11	Залруулсан үлдэгдэл	2,073,416,264.00	2,013,039,887.49	4,086,456,151.49
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(197,476,790.35)	(197,476,790.35)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	22,420,000.00	-	22,420,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
17	2024 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	2,095,836,264.00	1,815,563,097.14	3,911,399,361.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,980,781,468.31	3,934,947,308.66
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,835,978,155.25	2,386,955,487.72
1.1.2	Буцаан авсан албан татвар	48,613,706.06	
1.1.3	Татаас, санхүүжилтийн орлого	91,240,300.00	617,882,552.00
1.1.4	Бусад мөнгөн орлого	4,949,307.00	930,109,268.94
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,089,606,564.82	2,876,385,393.61
1.2.1	Ажиллагчдад төлсөн	196,497,422.67	479,501,948.09
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	56,349,362.61	134,386,369.01
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	347,046,427.33	1,526,830,166.22
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	110,318,919.58	174,740,340.68
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,647,758.00	38,934,632.37
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	363,083,794.69	330,514,017.11
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.8	Бусад мөнгөн зарлага	12,662,879.94	191,477,920.13
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	891,174,903.49	1,058,561,915.05
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		24,760,452.00
2.1.3	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт буцаан төлөлт		24,760,452.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,088,900.00	1,584,856,272.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,088,900.00	1,584,856,272.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,088,90)	(1,560,095,820.0)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,000,000.00	24,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	20,000,000.00	24,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	257,782,828.90	91,380,079.47
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	220,000,000.00	3,650,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	37,782,828.9	87,7360,079.47
3.2.5	Бусад		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(237,782,828.90)	(67,380,079,47)
4	Валютын ханшийн зөрүү		1,878.87
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	646,303,174.59	(568,912,105.55)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,031,773.70	703,334,948.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	703,334,948.29	134,422,842.74

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,121,108.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,884,504.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,615,574.4 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 2,121,108.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг бөгөөд мөн өргөн тархсан тул “Сөрөг” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Компанийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, 2024 оны 4 дүгээр сарын мөнгөн хөрөнгийн 37,279.8 мянган төгрөгийн орлогын, 70,861.6 мянган төгрөгийн зардлын, бараа материалын 99,854.1 мянган төгрөгийн орлогын, 18,045.8 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг санхүүгийн тайлангийн аудитад цаг хугацаанд нь ирүүлээгүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д “*төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх*”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “*Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг санхүүгийн тайлангийн аудитад цаг хугацаанд нь бүрэн ирүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Бараа материалын орлого, зардлын 117,899.9 мянган төгрөгийн гүйлгээнд анхан шатны баримт хангалтгүй няравын тайланг бэлтгээгүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 9.Бараа материалын тайлан НХМаягт БМ-9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын орлого, зардлын дүнгээр анхан шатны баримтыг үндэслэн няравын тайлан бэлтгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Ажил гүйцэтгэх болон худалдах худалдан авах гэрээ байгуулж 1,540,563.3 мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэхдээ гэрээний хэрэгжилтийг

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дүгнээгүй, үүргийн хэрэгжилтийн дүнд үндэслэн төлбөрийг төлөөгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана", 20 дугаар зүйлийн 20.1-д "Захирал дараах эрх үүрэгтэй 20.1.2.үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах,"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйцэтгэх болон худалдах худалдан авах гэрээний төлбөрийг гүйцэтгэхдээ гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, үүргийн хэрэгжилтийг үндэслэн төлбөрийг шилжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагнал

Илрүүлэлт 1: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу компанийн захирал эрхээ бүрэн хэрэгжүүлэн үйл ажиллагааны журам, бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөө, байгууллагын стратеги, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө зэрэг байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын бичиг баримтуудыг боловсруулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1-20.11 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагааны журам, бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөө, байгууллагын стратеги, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.

Илрүүлэлт 2: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн компанийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж, мөрдөж ажиллах.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт 3: Арилжааны банканд байршуулсан мөнгөн хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл 2024 оны байдлаар 191,586.4 мянган төгрөг байгаа бөгөөд энэхүү хөрөнгөөс хадгаламжийн хүүгийн орлого олох, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг хэрэгжүүлээгүй, харилцах данснаас зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, цахим хэлбэрээр төлбөрийг гүйцэтгэсэн

байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана: 1/ энэ хуульд заасан эрх, үүрэг; 2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгөө зөв, үр өгөөжтэй удирдах, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах, харилцах данснаас зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг хангаж, цахим хэлбэрээр төлбөрийг гүйцэтгэхгүй байх, төлбөрийн баримтаар зарцуулах.

3. Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт 4: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 18,045.8 мянган төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын зарлагын гүйлгээг анхан шатны бүрдэлийг бүрэн хийж, данс бүртгэлд тусгасан байх.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт 5: Газрын гэрчилгээнд 126,661 м² газар бүртгэлтэй байгаа боловч тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72, 73 дугаар зүйлийн холбогдох заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх", Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газар, гэрчилгээг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авах.

Илрүүлэлт 6: Ажилтан, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн карт нээгээгүй, эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 10 Ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл НХМаягт БМ-10-д заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх", Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтан, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн карт нээж, эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сайжруулах.

Илрүүлэлт 7: Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүрмийн сан, байгууллагын эзэмжиж байгаа хөрөнгийн дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь Төрийн

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх дүрмийн сан, байгууллагын эзэмжиж байгаа хөрөнгийн дүнгээс зөрүүтэй байгааг залруулах.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь 2024 оны 4 дүгээр сарын мөнгөн хөрөнгийн бараа материалын 226,041.3 мянган төгрөгийн орлого, зардлын анхан шатны баримтыг санхүүгийн тайлангийн аудитад ирүүлээгүй.	1	226,041.3			1	226,041.3						
Үйл ажиллагааны журам, бүтэгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөө, байгууллагын стратеги, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө зэрэг байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын бичиг баримтуудыг боловсруулаагүй байна.	1						1					
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.	1						1					
Харилцах данснаас зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг	1	191,586.4					1	191,586.4				

Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

хангаагүй, цахим хэлбэрээр төлбөрийг гүйцэтгэсэн байна.												
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан байна.	1	18,045.8					1	18,045.8				
Бараа материалын тайлан гаргаагүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй байна.	1	117,899.9			1	117,899.9						
Ажилтан, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн карт нээгээгүй, эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.	1						1					
Газрыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байна.	1						1					
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх дүрмийн сан, байгууллагын эзэмжшиж байгаа хөрөнгийн дүнгээс зөрүүтэй байна.	1	26,972.2					1	26,972.2				
Ажил гүйцэтгэх болон худалдах худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг гүйцэтгэхдээ гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, үүргийн хэрэгжилтийн дүнд үндэслэн төлбөрийг төлөөгүй байна.	1	1,540,563.3			1	1,540,563.3						
Дүн	10	2,121,108.9			3	1,884,504.5	7	236,604.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	1,378,970.1					1	1,378,970.1
Төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.	1				1			
Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг байршуулаагүй байна.	1						1	
Дүн	3	1,378,970.1			1		2	1,378,970.1

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1					1	
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1					1	